



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2026/115/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2026 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: С.Ариунбаяр Утас: 99076224 Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn</p>
--	---

аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1 Төлбөрийн акт	12
3.2 Албан шаардлага	12
3.3 Зөвлөмж	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.02.13 № 27

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн байдал алдагдаж, өр төлбөр үүссэн нөхцөлд бүтээмжийн урамшууллыг үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 107,338.9 мянган төгрөг олгосон, мөн спортын арга хэмжээ, уралдаан, бэлэг дурсгал зэрэг зориулалтын бус шинжтэй зардалд төсвийн хөрөнгө зарцуулсан байна. Түүнчлэн 59,700.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээний ажлыг хэсэгчлэн хувааж шууд гэрээ байгуулсан нь худалдан авах ажиллагааны өрсөлдөөнт зарчмыг хангаагүй, богино хугацаат өр төлбөр дансны үзүүлэлт болон авлагын дансны үзүүлэлтийг тооцож үзэхэд авлагаар өр төлбөрийг барагдуулах боломжгүй, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх чадахгүй байх нөхцөл үүссэн нь шинж чанарын хувьд материаллаг байдал үүссэн байна. Дээрх зөрчлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах шаардлагыг хангаагүй бөгөөд санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлд нөлөөлөхүйц бөгөөд Төсвийн тухай, төрийн хэмнэлтийн тухай, ТБОНӨХБАҮХАТХ-ийг бүрэн хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас тайлант онд 14,053,473.7 мянган төгрөгийг нэхэмжилсэн боловч 875,114.2 мянган төгрөгийг хасаж тооцсон. Хасагдлын шалтгаан, үр дагаврыг аудитын явцад нарийвчлан тогтоох боломжгүй нөхцөл үүссэн нь санхүүгийн тайланд тодорхойгүй байдал, аудитын үнэлгээний эрсдэл үүсгэж байна. Үүсгэсэн авлагаар үүссэн өр төлбөрийг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн бөгөөд иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг алдагдах эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын санхүүгийн байдал алдагдаж, өр төлбөр үүссэн, авлага-өглөгийн зохистой харьцаа хангагдаагүй, төсөв, хөрөнгийн хувьд зардлаа нөхөөгүй нөхцөлд бүтээмжийн урамшууллыг олгосон нь дотоод хяналт хангалтгүй, мэргэжлийн шийдэл гаргах чадвар дутмаг байгааг илтгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хамрах хүрээнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,867,917,539.18</u>	<u>1,345,382,891.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	94,648,837.45	19,694,837.04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	94,648,837.45	19,694,837.04
3121	Төгрөг	94,648,837.45	19,694,837.04
31211	Төрийн сангийн харилцах	93,352,715.45	19,694,837.04
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,296,122.00	00.00
33	АВЛАГА	952,706,571.80	641,650,011.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	937,206,571.80	614,150,011.60
335	Бусад авлага	15,500,000.00	27,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	15,000,000.00	27,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	500,000.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	820,562,129.93	684,038,042.49
351	Түүхий эд материал	461,627,623.51	298,922,687.27
35130	Эм боох материал	461,627,623.51	298,922,687.27
354	Хангамжийн материал	358,934,506.42	385,115,355.22
35410	Бичиг хэргийн материал	3,114,750.00	3,541,498.00
35420	Аж ахуйн материал	16,889,737.45	8,005,787.70
35430	Сэлбэг хэрэгсэл	7,035,250.00	7,035,250.00
35440	Түлш, шатах тослох материал	9,494,277.00	8,385,905.00
35450	Барилгын засварын материал	00.00	7,265,504.75
35460	Хүнсний материал	3,430,802.98	5,454,870.78
35470	Бусад хангамжийн материал	318,969,688.99	345,426,538.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,674,056,361.27</u>	<u>10,284,223,104.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,674,056,361.27	10,284,223,104.51
392	Биет хөрөнгө	11,219,772,361.27	9,829,939,104.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,493,126,098.00	6,493,126,098.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,008,157,927.80	-1,204,839,234.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,518,166,481.34	1,460,530,047.34
39204	Хуримтлагдсан элэгдэл	-682,497,000.39	-803,584,039.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,392,989,829.80	14,285,257,648.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,702,860,511.03	-10,540,118,229.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	762,363,778.32	766,434,378.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-559,051,336.75	-632,248,013.77
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,500,000.00	2,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,718,750.22	-2,031,250.26
39217	Ном	1,911,700.00	1,911,700.00
393	Биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>13,541,973,900.45</u>	<u>11,629,605,995.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,184,793,172.61</u>	<u>2,171,603,396.92</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,184,793,172.61	2,171,603,396.92
413	Өглөг	1,184,793,172.61	2,171,603,396.92
4136	Бусад өглөг	1,184,793,172.61	2,171,603,396.92
41361	Байгууллагад төлөх өглөг	1,155,928,672.61	2,138,102,286.92
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	28,864,500.00	33,501,110.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>12,357,180,727.84</u>	<u>9,458,002,598.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	12,357,180,727.84	9,458,002,598.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	3,682,328,865.24	3,682,328,865.24
51101	Өмч: - төрийн	3,682,328,865.24	3,682,328,865.24
512	Хуримтлагдсан үр дүн	5,315,570,114.48	2,416,391,985.36
51210	Өмнөх үеийн үр дүн	5,315,570,114.48	5,315,570,114.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,899,178,129.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,359,281,748.12	3,359,281,748.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>13,541,973,900.45</u>	<u>11,629,605,995.64</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	18,032,784,426.05	16,658,623,332.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,737,270,975.25	1,944,879,192.61
120	Нийтлэг татварын бус орлого	687,050,440.22	1,073,034,514.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	687,050,440.22	1,073,034,514.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	317,219,048.00	349,038,527.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,005,295.84	658,842,169.32
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	208,826,096.38	65,153,818.58
122	Тусламжийн орлого	2,080,106,135.03	871,844,677.71
122001	Хандив тусламж /дотоод/	2,080,106,135.03	871,844,677.71
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	970,114,400.00	00.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн	970,114,400.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,295,513,450.80	14,713,744,140.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,280,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	43,280,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,210,406,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,210,406,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,252,233,450.80	13,503,337,640.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,252,233,450.80	13,503,337,640.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,878,423,969.64	19,556,949,443.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,878,423,969.64	19,556,949,443.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,859,373,814.64	19,024,358,134.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,354,785,662.77	9,647,740,308.45
210101	Үндсэн цалин	4,853,525,661.85	5,574,543,710.73
210102	Нэмэгдэл	2,534,117,115.92	2,793,383,967.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	306,744,000.00	410,184,000.00
210104	Урамшуулал	660,398,885.00	869,628,630.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	1,076,804,771.90	1,189,569,884.80
210201	Тэтгэврийн даатгал	737,700,839.19	812,039,844.75
210202	Тэтгэмжийн даатгал	89,113,352.51	98,614,579.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	65,119,943.10	71,936,891.05
210204	Ажилгүйдлийн даатгал	36,911,957.45	41,377,842.16
210205	Эрүүл мэндийн даатгал	147,958,679.65	165,600,727.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	923,897,831.84	1,176,200,016.23
210301	Гэрэл, цахилгаан	140,320,651.19	141,748,082.36
210302	Түлш, халаалт	612,720,580.65	872,485,813.87
210303	Цэвэр, бохир ус	170,856,600.00	161,966,120.00

2104	Хангамж, бараа материалын зардал	332,324,954.20	376,797,057.16
210401	Бичиг хэрэг	40,594,155.00	31,802,197.00
210402	Тээвэр, шатахуун	189,348,021.00	145,486,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,372,731.80	1,652,415.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	9,664,444.00	11,846,351.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	85,345,602.40	114,645,234.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	71,364,460.02
2105	Нормативт зардал	4,714,942,852.53	3,976,369,123.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,377,961,319.20	3,587,067,132.64
210502	Хоол, хүнс	336,981,533.33	389,301,990.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	209,860,145.00	133,449,270.00
210604	Урсгал засвар	209,860,145.00	133,449,270.00
2107	Томилолт, зочны зардал	71,783,400.00	60,352,300.00
210702	Дотоод албан томилолт	71,783,400.00	60,352,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	27,715,035.50	121,930,640.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,118,736.00	102,764,372.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,420,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	5,065,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	497,557.00	492,266.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231,000.00	263,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,118,038.50	10,620,298.25
210807	Газрын төлбөр	2,725,704.00	2,725,704.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын хураамж	10,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,094,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,147,259,160.90	2,341,949,534.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,677,000.00	7,477,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,639,300.00	2,847,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,132,942,860.90	2,331,625,234.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,050,155.00	532,591,308.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,995,400.00	532,493,980.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	00.00	229,500,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	276,132,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,995,400.00	26,861,580.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,755.00	97,328.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,755.00	97,328.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>154,360,456.41</u>	<u>-2,898,326,111.12</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	365,959.33	852,018.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	365,959.33	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	852,018.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-365,959.33	-852,018.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>153,994,497.08</u>	<u>-2,899,178,129.12</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>15,148,287,482.05</u>	<u>16,037,609,699.07</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,433,338,743.25</u>	<u>1,000,808,998.87</u>

120	Нийтлэг татварын бус орлого	463,224,343.25	1,000,808,998.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	463,224,343.25	1,000,808,998.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	317,219,048.00	349,038,527.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	146,005,295.25	651,770,471.87
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	970,114,400.00	00.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлэг	970,114,400.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,714,948,738.80	15,036,800,700.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,280,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	43,280,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,210,406,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,210,406,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,671,668,738.80	13,826,394,200.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,671,668,738.80	13,826,394,200.20
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>15,039,136,484.55</u>	<u>16,042,616,399.48</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,039,136,484.55	16,042,616,399.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,007,332,644.55	15,520,418,116.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,685,308,026.40	9,647,785,308.45
210101	Үндсэн цалин	4,854,539,063.33	5,602,047,891.63
210102	Нэмэгдэл	2,716,554,835.31	2,778,703,760.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	306,743,824.13	411,304,220.77
210104	Урамшуулал	807,470,303.63	855,729,435.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	1,076,262,408.71	1,189,569,884.80
210201	Тэтгэврийн даатгал	736,223,218.58	812,039,844.75
210202	Тэтгэмжийн даатгал	89,098,304.54	98,614,579.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	66,107,868.40	71,936,891.05
210204	Ажилгүйдлийн даатгал	36,904,433.47	41,377,842.16
210205	Эрүүл мэндийн даатгал	147,928,583.72	165,600,727.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,100,348,800.00	1,190,435,473.07
210301	Гэрэл, цахилгаан	140,413,051.19	142,107,707.36
210302	Түлш, халаалт	801,499,138.81	872,574,135.71
210303	Цэвэр, бохир ус	158,436,610.00	175,753,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал	302,157,180.30	262,275,630.59
210401	Бичиг хэрэг	29,671,550.00	24,871,190.00
210402	Тээвэр, шатахуун	180,548,866.00	143,245,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,669,770.30	6,707,399.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	10,423,144.00	12,404,851.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,843,850.00	75,046,850.00
2105	Нормативт зардал	3,524,316,767.14	2,896,582,990.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,204,535,132.64	2,498,997,354.54
210502	Хоол, хүнс	305,368,914.50	379,025,586.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,412,720.00	18,560,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,115,315.00	148,846,738.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,420,500.00	18,559,700.00
210602	Тавилга	8,365,900.00	707,000.00
210604	Урсгал засвар	173,328,915.00	129,580,038.00
2107	Томилолт, зочны зардал	60,781,800.00	56,944,600.00
210702	Дотоод албан томилолт	60,781,800.00	56,944,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,687,997.00	97,142,942.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,118,736.00	83,999,972.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,420,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	5,020,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	497,557.00	492,266.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231,000.00	263,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,765,000.00	2,017,000.00
210807	Газрын төлбөр	2,725,704.00	2,725,704.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын хураамж	10,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,420,000.00	2,625,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,354,350.00	30,834,549.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,114,750.00	27,987,549.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,239,600.00	2,847,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,803,840.00	522,198,282.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,749,085.00	522,100,954.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	00.00	229,500,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	276,132,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,749,085.00	16,468,554.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,755.00	97,328.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,755.00	97,328.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	109,150,997.50	-5,006,700.41
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	85,319,190.00	69,947,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,319,190.00	69,947,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	85,319,190.00	69,947,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,319,190.00	69,947,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-85,319,190.00	-69,947,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	23,831,807.50	-74,954,000.41
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70,817,029.95	94,648,837.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	94,648,837.45	19,694,837.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	8,364,837,716.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	8,364,837,716.73
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-356,452,562.36	-356,452,562.36
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,315,570,114.48	12,357,180,727.84
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,315,570,114.48	12,357,180,727.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	5,315,570,114.48	12,357,180,727.84
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,899,178,129.1	-2,899,178,129.12
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	2,416,391,985.36	9,458,002,598.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,929,853,400	14,900,861,077
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,929,853,400	14,900,861,077
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,425,054,200	14,379,960,123
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,650,709,600	9,647,785,308
210101	Үндсэн цалин	5,724,152,400	5,602,047,891
210102	Нэмэгдэл	2,954,758,800	2,778,703,760
210103	Унаа хоолны хөнгөлөлт	472,464,000.0	411,304,220.8
210104	Урамшуулал	499,334,400.0	855,729,435.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,228,883,500	1,189,569,884
210201	Тэтгэврийн даатгал	826,364,000.0	812,039,844.8
210202	Тэтгэмжийн даатгал	100,629,900.0	98,614,579.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,314,900.0	71,936,891.1
210204	Ажилгүйдлийн даатгал	50,314,900.0	41,377,842.2
210205	Эрүүл мэндийн даатгал	201,259,800.0	165,600,727.0
2104	Хангамж, бараа материалын зардал	263,151,800.0	262,950,630.6
210401	Бичиг хэрэг	19,529,600.0	24,871,190.0
210402	Тээвэр, шатахуун	150,000,000.0	143,245,340.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,700,000.0	6,707,399.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,000,000.0	12,404,851.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,922,200.0	75,721,850.0
2105	Нормативт зардал	2,911,082,500	2,911,081,890
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,582,739,800	2,513,496,254
210502	Хоол, хүнс	310,942,700.0	379,025,586.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,400,000.0	18,560,050.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	183,724,000.0	183,650,318.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	62,550,000.0	59,661,600.0
210602	Тавилга	4,427,500.0	13,625,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.0	-
210604	Урсгал засвар	113,746,500.0	110,363,718.0
2107	Томилолт, зочны зардал	56,960,800.0	56,944,600.0
210702	Дотоод албан томилолт	56,960,800.0	56,944,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,542,000.0	97,142,942.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,000,000.0	83,999,972.0
210803	Даатгалын үйлчилгээ	5,920,000.0	5,020,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	800,000.0	492,266.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	700,000.0	263,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,017,000.0	2,017,000.0
210807	Газрын төлбөр	2,880,000.0	2,725,704.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,625,000.0	2,625,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,000,000.0	30,834,549.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,000,000.0	27,987,549.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	2,847,000.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	504,799,200.0	520,900,954.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	504,799,200.0	520,900,954.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	272,829,000.0	229,500,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	216,788,000.0	276,132,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,182,200.0	15,268,554.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,861,326,800	14,827,203,199
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,745,162,200	13,826,394,200
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,745,162,200	13,826,394,200
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,116,164,600	1,000,808,998
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	463,275,700.0	349,038,527.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	652,888,900.0	651,770,471.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	93,352,715.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,694,837.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	330.0	330.0
620001	Удирдах ажилтан	2.0	2.0
620002	Гүйцэтгэх ажилтан	255.0	255.0
620003	Үйлчлэх ажилтан	73.0	73.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,210,405,293.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,210,405,293.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,210,405,293.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,190,435,473.07
210301	Гэрэл, цахилгаан		142,107,707.36
210302	Түлш, халаалт		872,574,135.71
210303	Цэвэр, бохир ус		175,753,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		19,969,820.00
210604	Урсгал засвар		19,969,820.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 169,177.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 107,927.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 61,250.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгийн ашиглалт, өр төлбөр, авлагын данстай холбоотой зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Байгууллагын санхүүгийн байдал алдагдаж, өр төлбөр үүссэн, авлага өглөгийн зохистой харьцаа хангагдаагүй байхад Удирдлагын зөвлөлийн шийдвэрээр бодит бүтээмжийг нотолсон үндэслэлгүйгээр бүтээмжийн урамшууллыг үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 107,338.9 мянган төгрөг олгосон нь төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг, зохистой байдлын шаардлагад нийцэхгүй байна.

Илрүүлэлт: Албан хаагчдын дунд спортын арга хэмжээ зохион байгуулж даргын тушаалаар шагнал олгосон, зочид төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 589.0 мянган төгрөг зарцуулсан.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглагддаг компьютер, техник хэрэгслийн засвар үйлчилгээний ажлыг багцлан нэг тендер сонгон шалгаруулалт зарлах боломжтой 59,700.0 мянган төгрөгийн ажлыг хэсэгчлэн хувааж, 2 аж ахуйн нэгжтэй 3 төрлийн шууд гэрээ байгуулсан байна.

Илрүүлэлт: Албан хаагчдын дунд эрдмийн чуулган, дэлхийн тамхины эсрэг өдрийг угтаж хүүхдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулж төсвөөс 1,550.0 мянган төгрөгийн шагнал олгосон.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1², 16 дугаар зүйлийн 16.5.5³, 41 дүгээр зүйлийн 41.2.2⁴, 41.2.3⁵, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3⁶ 15.1.5⁷, 15.1.8⁸, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.3⁹-т заасныг тус тус зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Уламжлалын нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн, гадна талбайн тохижилтын ажилтай холбоотой буулгасан саравч данс бүртгэлээс хасаагүй, сувиллын зориулалтаар ашиглаж байсан модон байшин хадгалалт хамгаалалтгүйгээс эвдэрч гэмтсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

³ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁴ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

⁵ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁶ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

⁷ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах.

⁸ байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах.

⁹ Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

Өгсөн зөвлөмж: Уламжлалтын нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн болон буулгасан саравчийг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж бүртгэлээс хасах, сувиллын зориулалтаар ашиглаж байсан хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах;

2. ЭМДС-ийн нэхэмжлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн санхүүжилтийн хасагдлын 14.1 хувь нь эмчийн үзлэгийг цахим системд алдаатай бүртгэснээс үүдэлтэй байгаа нь мэдээллийн бүртгэлийн хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын удирдлага эмчийн ажил дүгнэх журамд Эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжлэлийн хасагдалтай холбоотой шалгуур үзүүлэлтийг тусган, хасагдлын шалтгаан, давтамжид үндэслэн гүйцэтгэлийг үнэлэх, урьдчилсан дотоод хяналт болон давхар баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх, зорилтот сургалт зохион байгуулах замаар алдааг бууруулж, ажлын үр дүн болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны жилийн эцэст 2.1 тэрбум төгрөгийн өглөг бүртгэгдсэн бол 0.7 тэрбум төгрөгийн авлагатай байна. Энэ нь бүртгэсэн авлагаар өр төлбөрийг барагдуулах боломжгүй, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиг үүрэг алдагдах нөхцөл байдал үүссэн.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын удирдлага богино хугацаанд төлбөрийн чадварыг сэргээх зорилгоор авлага, өглөгийн барагдуулалтыг эрчимжүүлэх төлөвлөгөө баталж, өглөгийг эрэмбэлэн зохицуулах, зардлын бүтцэд дүн шинжилгээ хийж үр ашиггүй зардлыг бууруулах, мөнгөн урсгалын сар, улирлын төлөвлөлтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан тогтмол хянах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх замаар төсвийн хөрөнгийн үр ашиг, санхүүгийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал давхардуулан олгосон	1	107,338.8	1	107,338.8						

Тендерийн хууль зөрчсөн	1	59,700.0			1	59,700.0				
Чиг үүрэгт хамраалгүй шагнал олгосон	1	1,550.0			1	1,550.0				
ЭМДС-ийн хасагдалтай холбоотой	1						1			
Үндсэн хөрөнгөтэй холбоотой	1						1			
Өр төлбөртэй холбоотой	1						1			
Дүн	6	169,177.9	1	107,338.8	2	61,250.0	3	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Спортын арга хэмжээ, бэлэг дурсгалд хөрөнгө олгосон	1	539.0	1	539.0				
Дүн	2	539.0	1	539.0	1			